

НИЙГМИЙН ДААТРГАЛЫН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

Зааварт нэмэлт, өөрчлөлт оруулах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэг, Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 37 дугаар зүйлийн 37.13.1, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.3 дахь хэсэг, Нийгмийн даатгалын сангаас олгох Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1 дэх хэсэгт заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2025 оны А/267 дугаар тушаалаар баталсан “Тэтгэмж бодох заавар”-ын “Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний улмаас хөдөлмөрийн чадвараа түр алдсан даатгуулагчид хөдөлмөрийн чадвараа түр алдсаны тэтгэмж бодох” 8 дугаар хэсэгт “Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний улмаас хөдөлмөрийн чадвар түр алдсан хугацааны ажлын эхний 5 өдрийн хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмжийг ажил олгогчоос, 6 дахь өдрөөс эхлэн хөдөлмөрийн чадвар алдсаны тэтгэвэр авах эрх үүсэх хүртэл хугацааны тэтгэмжийг үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангаас тус тус олгоно.” гэсэн агуулга бүхий 8.7 дахь заалтыг шинээр нэмсүгэй.

2. Зааврын “Ажилгүйдлийн тэтгэмж бодох” гэсэн 7 дахь хэсгийн 7.2 дахь заалтаас “ нь ажлаас чөлөөлсөн эсхүл” гэснийг хассугай.

3. Зааврын 6 дахь хэсгийн 6.2 дахь заалтын “Санамж¹⁸”-ийг “Нас барсан даатгуулагчийн гэр бүлийн гишүүнд олгох тэтгэмжийг Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн тогтоолоор баталсан хэмжээгээр олгоно.” гэж, 4 дэх хэсгийн 4.3 дахь заалтын “Санамж⁶”-ийг “Тэтгэмж бодох сүүлийн дараалсан 3 сарын цалин хөлсөнд даатгуулагчийн төрлийн “1”, “3”, “4”-өөр төгссөн кодтой цалин хөлсийг сонгоно. Хэрэв 3 сарын цалин хөлсөнд даатгуулагчийн төрлийн “2”-оор төгссөн кодтой цалин хөлс орохоор бол даатгуулагчийн өмнөх сарын даатгуулагчийн төрлийн “1”, “3”, “4”-өөр төгссөн кодтой цалин хөлсийг оруулан 3 сарыг гүйцээж, тэтгэмж бодох сарын дундаж цалин хөлсийг тодорхойлно” гэж, 5 дахь хэсгийн 5.3 дахь заалтын “Санамж¹²”-ийг “Тэтгэмж бодох сүүлийн 12 сарын цалин хөлсөнд даатгуулагчийн төрлийн “1”, “3”, “4”-өөр төгссөн кодтой цалин хөлсийг сонгоно. Хэрэв 12 сарын цалин хөлсөнд даатгуулагчийн төрлийн “2”-оор төгссөн кодтой цалин хөлс орохоор бол өмнөх сарын даатгуулагчийн төрлийн “1”, “3”, “4”-өөр төгссөн код бүхий цалин хөлсийг оруулан 12 сарыг гүйцээж, тэтгэмж бодох сарын дундаж цалин хөлсийг тодорхойлно.” гэж тус тус өөрчлөн найруулсугай.

4. Энэхүү зааварт оруулсан нэмэлт, өөрчлөлтийг мөрдөж ажиллахыг аймаг, дүүргийн Нийгмийн даатгалын газрын дарга нарт, мэргэжил арга зүйгээр хангаж ажиллахыг Бодлогын хэрэгжилт, төлөвлөлтийн газар (Ц.Ганцэцэг)-т, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт шалгалтын газар (С.Лхагвадорж)-т тус тус үүрэг болгосугай.

5.Энэ тушаалын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Дотоод аудит, мониторингийн газар (Б.Ганхуяг)-т даалгасугай.

ДАРГА

Б.БАТЖАРГАЛ

ТӨСӨЛ